



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/184/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: Khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: Х.Манаргүл Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Төсвийн захирагч



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өггхий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ТӨВИЙН ДАРГА Ч.ҮРЖИХ ТАНАА

2022.02.14 № 60
тантай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>35,942,887.00</u>	<u>29,816,143.00</u>
33	АВЛАГА	1,300,060.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,300,060.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	34,642,827.00	29,816,143.00
351	Түүхий эд материал	4,768,262.00	883,595.00
35130	Эм боох материал	4,768,262.00	883,595.00
354	Хангамжийн материал	29,874,565.00	28,932,548.00
35410	Бичиг хэргийн материал	239,100.00	418,500.00
35420	Аж ахуйн материал	28,249,185.00	28,109,370.00
35430	Сэлбэг хэрэгсэл	182,100.00	182,100.00
35440	Түлш, шатах тослох материал	1,196,180.00	214,578.00
35470	Бусад хангамжийн материал	8,000.00	8,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>853,364,542.59</u>	<u>828,399,396.77</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	853,364,542.59	828,399,396.77
392	Биет хөрөнгө	787,614,542.59	762,649,396.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	756,547,040.67	756,547,040.67
39202	Хуримтлагдсан элэгдэл	(34,240,763.00)	(46,867,880.36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	64,967,000.00	64,967,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(50,117,000.00)	(56,057,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	139,056,195.68	145,929,395.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	(108,725,081.17)	(118,873,895.96)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,545,508.00	16,445,508.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,380,857.59)	(9,865,771.26)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,350,000.00	14,350,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,387,500.00)	(3,925,000.00)
393	Биет бус хөрөнгө	65,750,000.00	65,750,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	65,750,000.00	65,750,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>889,307,429.59</u>	<u>858,215,539.77</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>379,427.00</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	379,427.00	-
413	Өглөг	379,427.00	-
4136	Бусад өглөг	379,427.00	-
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	379,427.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>888,928,002.59</u>	<u>858,215,539.77</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	888,928,002.59	858,215,539.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	309,088,442.00	309,088,442.00
51101	Өмч: - төрийн	309,088,442.00	309,088,442.00

512	Хуримтлагдсан үр дүн	31,465,267.44	752,804.62
51210	Өмнөх үеийн үр дүн	21,237,185.63	31,465,267.44
51220	Тайлант үеийн үр дүн	10,228,081.81	(30,712,462.82)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	548,374,293.15	548,374,293.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	889,307,429.59	858,215,539.77

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	559,508,213.50	592,614,358.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,447,062.50	47,634,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	28,447,062.50	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	28,447,062.50	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	28,447,062.50	
122	Тусламжийн орлого	-	47,634,400.00
122001	Хандив тусламж /дотоод/		47,634,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	531,061,151.00	544,979,958.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	470,983,400.00	471,832,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	456,983,700.00	471,832,400.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	13,999,700.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,077,751.00	73,147,558.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,748,450.00	22,429,558.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,592,051.00	50,718,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,737,250.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	528,640,779.19	623,326,820.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	528,640,779.19	623,326,820.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	528,097,567.19	583,676,350.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	382,722,212.00	375,670,432.00
210101	Үндсэн цалин	237,938,871.00	270,049,709.00
210102	Нэмэгдэл	100,426,745.60	58,062,961.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,444,209.40	16,903,000.00
210104	Урамшуулал	25,912,386.00	30,654,762.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,520,577.00	53,873,686.00
210201	Тэтгэврийн даатгал	52,520,577.00	53,873,686.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,125,679.00	8,742,422.00
210301	Гэрэл, цахилгаан	1,156,907.00	1,312,922.00
210302	Түлш, халаалт	6,968,772.00	7,429,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,577,770.00	15,694,165.00
210401	Бичиг хэрэг	983,600.00	979,100.00
210402	Тээвэр, шатахуун	9,142,870.00	10,132,600.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	209,800.00	1,286,500.00
210404	Ном, хэвлэл	241,500.00	472,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	2,823,165.00
2105	Нормативт зардал	14,486,278.00	16,452,235.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,957,758.00	15,367,235.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,528,520.00	1,085,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,109,690.00	71,857,065.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	317,000.00	234,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,430,890.00	69,046,665.00
210604	Урсгал засвар	1,361,800.00	2,576,200.00
2107	Томилолт, зочны зардал	7,729,500.00	7,256,000.00
210702	Дотоод албан томилолт	7,729,500.00	7,256,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,529,200.00	1,392,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	350,000.00	350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,500.00	106,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,489,200.00	405,000.00
210807	Газрын төлбөр	131,500.00	131,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	90,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,296,661.19	32,738,345.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,710,000.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	34,586,661.19	32,738,345.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	543,212.00	39,650,470.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	39,640,060.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	39,640,060.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	43,212.00	10,410.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,212.00	10,410.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	30,867,434.31	(30,712,462.82)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	20,639,352.50	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	20,639,352.50	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(20,639,352.50)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	10,228,081.81	(30,712,462.82)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	309,088,442.00	548,374,293.15	31,465,267.44	888,928,002.59
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	309,088,442.00	548,374,293.15	31,465,267.44	888,928,002.59
Тайлант үеийн үр дүн			(30,712,462.82)	(30,712,462.82)

2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	309,088,442.00	548,374,293.15	752,804.62	858,215,539.77
---------------------------------------	----------------	----------------	------------	----------------

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	517,061,451.00	546,280,018.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	517,061,451.00	546,280,018.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	456,983,700.00	471,832,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	456,983,700.00	471,832,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,077,751.00	74,447,618.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,748,450.00	22,429,558.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,592,051.00	52,018,060.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,737,250.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	512,967,651.00	538,506,818.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	512,967,651.00	538,506,818.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	511,124,379.00	498,856,348.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	379,974,106.00	375,240,635.00
210101	Үндсэн цалин	239,440,840.00	238,868,490.00
210102	Нэмэгдэл	98,781,674.60	83,497,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,125,609.40	18,701,545.00
210104	Урамшуулал	24,625,982.00	34,173,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,889,256.00	54,682,910.00
210201	Тэтгэврийн даатгал	37,061,756.00	36,472,610.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,565,500.00	3,642,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,417,900.00	6,555,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	713,100.00	728,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,131,000.00	7,284,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,964,457.00	8,327,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,156,907.00	1,312,922.00
210302	Түлш, халаалт	6,807,550.00	7,014,078.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,697,050.00	15,937,385.00
210401	Бичиг хэрэг	998,200.00	993,500.00
210402	Тээвэр, шатахуун	9,709,050.00	9,566,420.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	209,800.00	1,286,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	780,000.00	1,249,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,841,165.00
2105	Нормативт зардал	22,069,120.00	17,906,568.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,341,700.00	11,482,568.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,727,420.00	6,424,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,561,690.00	17,798,850.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	962,600.00	1,341,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	14,237,290.00	13,881,650.00
210604	Урсгал засвар	1,361,800.00	2,576,200.00
2107	Томилолт, зочны зардал	7,729,500.00	7,256,000.00
210702	Дотоод албан томилолт	7,729,500.00	7,256,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,529,200.00	1,707,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	350,000.00	350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,500.00	106,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,489,200.00	720,000.00
210807	Газрын төлбөр	131,500.00	131,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	90,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,710,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,710,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,843,272.00	39,650,470.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	39,640,060.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	39,640,060.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,343,272.00	10,410.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,343,272.00	10,410.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,093,800.00	7,773,200.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,093,800.00	7,773,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,093,800.00	7,773,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,093,800.00	7,773,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,093,800.00	7,773,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(4,093,800.00)	(7,773,200.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	471,832,400.00	471,822,663.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	471,832,400.00	471,822,663.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	471,292,400.00	471,282,663.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	364,205,200.00	364,195,745.00
210101	Үндсэн цалин	227,823,600.00	227,823,600.00
210102	Нэмэгдэл	83,497,100.00	83,497,100.00

210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,711,000.00	18,701,545.00
210104	Урамшуулал	34,173,500.00	34,173,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,809,800.00	52,809,800.00
210201	Тэтгэврийн даатгал	34,599,500.00	34,599,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,642,100.00	3,642,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,555,700.00	6,555,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	728,400.00	728,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,284,100.00	7,284,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,327,000.00	8,327,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,040,000.00	1,312,922.00
210302	Түлш, халаалт	7,287,000.00	7,014,078.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,527,500.00	13,527,300.00
210401	Бичиг хэрэг	993,500.00	993,500.00
210402	Тээвэр, шатахуун	7,353,500.00	7,353,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,286,500.00	1,286,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,250,000.00	1,249,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,644,000.00	2,644,000.00
2105	Нормативт зардал	11,840,900.00	11,840,818.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,054,900.00	7,054,818.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,786,000.00	4,786,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,303,800.00	7,303,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,946,000.00	1,946,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,439,800.00	3,439,800.00
210604	Урсгал засвар	1,918,000.00	1,918,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,500,000.00	6,500,000.00
210702	Дотоод албан томилолт	6,500,000.00	6,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,778,200.00	6,778,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	350,000.00	350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	106,500.00	106,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,791,200.00	5,791,200.00
210807	Газрын төлбөр	131,500.00	131,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	540,000.00	540,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	540,000.00	540,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	540,000.00	540,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	471,832,400.00	471,822,663.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	471,832,400.00	471,822,663.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	471,832,400.00	471,822,663.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27	27
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7

620003	Үйлчлэх ажилтан	19	19
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	27	27
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	20	20
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,777,691.00	74,446,945.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,777,691.00	74,446,945.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	58,777,691.00	35,346,885.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	23,423,195.00	11,044,890.00
210101	Үндсэн цалин	23,423,195.00	11,044,890.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,189,356.00	1,873,110.00
210201	Тэтгэврийн даатгал	3,189,356.00	1,873,110.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,555,550.00	2,410,085.00
210402	Тээвэр, шатахуун	3,555,550.00	2,212,920.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		197,165.00
2105	Нормативт зардал	11,262,200.00	6,065,750.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,320,700.00	4,427,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	941,500.00	1,638,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,407,890.00	13,197,050.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	386,400.00	1,197,000.00
210602	Тавилга		900,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	12,021,490.00	10,441,850.00
210604	Урсгал засвар		658,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,229,500.00	756,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	1,229,500.00	756,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,710,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,710,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	39,100,060.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	39,100,060.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		39,100,060.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,300,060.00	673.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,300,060.00	673.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	60,077,751.00	74,447,618.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,077,751.00	74,447,618.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,748,450.00	22,429,558.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,592,051.00	52,018,060.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,737,250.00	
131106	Төсвийн урамшуулал		
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 57 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн зорилго нь: Аймгийн хэмжээнд зоонозын өвчний хяналт тандалтыг оновчтой төлөвлөх, зоонозын шинэ ба сэргэн тархаж буй халдварт өвчнүүд болон тарваган тахал өвчнөөс эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах, мэдээлэл, сургалт сурталчилгааг эрчимжүүлэн хүн амд зоонозын өвчнөөс сэргийлэх талаар эрүүл мэндийн боловсрол олгох замаар халдварын эрсдэлийг багасган хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулах

Дээрх зорилгынхоо хүрээнд дараах зорилтыг тавьж ажилласан байна.Үүнд:

1. Аймгийн хэмжээнд шинэ ба сэргэн тархаж буй зоонозын халдварт өвчний байгалийн голомтын шинжилгээг оновчтой явуулснаар голомтыг илрүүлэх, хянах, орон нутгийн зэрэглэлд оруулж бүсчлэх
2. Шинэ ба сэргэн тархаж буй зоонозын болон байгалийн голомтот халдварт өвчний лабораторийн шинжилгээ, оношилгооны бэлэн байдлыг хангах
3. Шинэ ба сэргэн тархаж буй зоонозын болон байгалийн голомтот халдварт өвчний голомт хяналтын шинжилгээнд голомтын төлөвийг лабораторийн шинжилгээгээр батлах
4. Шинэ ба сэргэн тархаж буй зоонозын халдварт өвчнөөс эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээний сургалт зохион байгуулах
5. Байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах
6. Ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулж ажилтан албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх
7. Байгууллагын удирдлага хөгжлийг сайжруулах
8. Дархлаажуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах дэглэмийн мөрдөлт хяналтыг сайжруулах

Аймгийн хэмжээнд шинэ ба сэргэн тархаж буй байгалийн голомтот, зоонозын халдварт өвчний чиглэлээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, бусад мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах чиг үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Зоонозын өвчин судлалын төвд дотоод аудитын нэгжгүй бөгөөд байгууллагын даргын тушаалаар дотоод хяналтын 3 хүний бүрэлдэхүүнтэй багийг байгуулж үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна, мөн тайлант онд аймгийн Санхүү хяналт, аудитын албанаас 2019-2020 онуудын санхүүгийн баримтад шалгалт хийж 0.3 сая төгрөгийн акт тогтоосон, өөр алдаа зөрчил илрээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 529.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 10.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос сая төгрөгөөр буюу хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,300.1	-	(1,300.1)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	34,642.8	29,816.1	(4,826.7)
Үндсэн хөрөнгө	853,364.5	828,399.4	(24,965.1)

Нийт хөрөнгө	889,307.4	858,215.5	(31,091.9)
Өр төлбөр	379.4	-	(379.4)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	888,928.0	858,215.5	(30,712.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	889,307.4	858,215.5	(31,091.9)

Мөнгөн хөрөнгийн данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна. Авлагын данс оны эцэст үлдэгдэлгүй гарч оны эхнээс 1,3 сая төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 29.8 сая төгрөг болж 4.8 сая төгрөгөөр буурсан байна. Төсвийн хөрөнгөөр 55.3 сая төгрөгийн бараа материалыг худалдан, аймгийн Засаг даргын тамгын газрын бүрдүүлсэн нөөцөөс 47.6 сая төгрөгийн бараа материал(хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, нэг удаагийн хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис)-ыг үнэ төлбөргүй хүлээн авч 107.7 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө 24.9 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 7.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, үндсэн хөрөнгөнд 32.7 сая төгрөгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлжээ.

Оны эхний 0.4 сая төгрөгийн өглөгийг барагдуулж, оны эцэст өглөггүй байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 858.2 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 29.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Зооноз өвчин судлалын төвийн 2021 оны төсвийг 471.8 сая төгрөгөөр баталсан ба тодотголоор өөрчлөлт ороогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд гүйцэтгэлээр улсын төсвөөс 471.8 сая төгрөгийг санхүүжилт хүлээн авч үйл ажиллагаанд зарцуулж, хэмнэгдсэн 0.009 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зарлагын 88.4 хувийг ажиллагсадтай холбоотой зардал, 11.6 хувийг бусад бараа үйлчилгээний зардал эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Эрүүл мэндийн яамнаас 52.0 сая, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 19.3 сая, Орон нутгийн хөгжлийн сангаас 3.1 сая, бүгд 74.4 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/248, А/496 , А/585 тоот тушаалуудаар Ковид-19-ын эрсдэлээс сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг урамшуулах зорилгоор нэг удаагийн тэтгэмж болон илүү цагийн хөлст бүгд 52.0 сая төгрөгийг олгосон байна.

Ковид-19 өвчлөлийн үед бэлэн байдлыг хангах, мөн сэжигтэй тохиолдлын үед ариутгал, халдваргүйтгэл хийхэд ажилласан ажилчдын илүү цагийн хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд 12.9 сая, урамшуулалд 39.1 сая төгрөг зарцуулжээ.

Аймгийн Засаг даргын захирамжаар олгосон 22.4 сая төгрөгөөс COVID-19 өвчлөлийн сэжигтэй тохиолдлын үед ажилласан албан хаагчдын албан томилолтод 0.8 сая төгрөг, хөдөлмөр хамгаалалд 12.5 сая төгрөг, ариутгалын бодис, эм реактивийн зардалд 6.1 сая, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлд 0.2 сая, тээвэр шатахуунд 2.2 сая, запас сэлбэгт 0.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд 2021 оны санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл гараагүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Аймгийн Нийгмийн халамжийн сан /Улсын төсөв/ нь 2021 онд нийт 471.8 сая төгрөгийн 173 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 471.8 сая төгрөгийн 173 мэдээллийг хугацаандаа байршуулсан байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээ, өр, авлага гараагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар шилэн данснтай холбоотой зөрчилд өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил гараагүй болно.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй

4.2 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй

4.3 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн